



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдаа зохион байгуулах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, сэргээн засварлах боломжгүй нийт 164,314,466.39 (нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун арван дөрвөн мянга дөрвөн зуун жаран зургаан төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 110,347,799.59 (нэг зуун арван сая гурван зуун дөчин долоон мянга долоон зуун ерэн есөн төгрөг тавин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 4 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадоржид дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдаа зохион байгуулах зардал, холбогдох төлбөр, тооцоог хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000110

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 03 дугаар сарын 3/-ны өдрийн  
175 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААНТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Хьюндай Соната 6, 10-15 УБА, КМННУ41МР7А273322	2007/2011	ш	1	21,500,000.00	21,500,000.00	-	2,000,000.00
2	Волксваген Тигуан, 90-18 УНЗ, WVGZZ5NZAVW087809	2010/2010	ш	1	58,814,466.39	58,814,466.39	-	5,000,000.00
3	Форд транзит, 48-91 ОРХ	2018	ш	1	49,000,000.00	18,199,999.88	30,800,000.12	50,000,000.00
4	Форд транзит машины чиргүүл, 42-22 ГЧ	2018	ш	1	35,000,000.00	11,833,333.32	23,166,666.68	57,000,000.00
Нийт дүн					164,314,466.39	110,347,799.59	53,966,666.80	(тавин долоон сая)
					(нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун арван дөрвөн мянга дөрвөн зуун жаран зургаан төгрөг гучин есөн мөнгө)	(нэг зуун арван сая гурван зуун дөчин долоон мянга дөрвөн зуун есөн төгрөг тавин есөн мөнгө)	(тавин гурван сая есөн зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг наян мөнгө)	